



СЭДЭВ: МЭРГЭЖЛИЙН
ХОЛБООДОД ЖДҮ ЭРХЛЭГЧ
БОЛОН ХОРШООДЫН
ОРОЛЦОХ ҮҮРЭГ

“БАЯЛАГ БҮТЭЭГЧДИЙГ
ДЭМЖИХ ХОЛБОО” ТББ-
ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.БАТДЭЛГЭР



ЖДҮ-ИЙН ХӨГЖИЛ

Монгол улсын хувьд 1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос чөлөөт зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн үеэс нийгэм, эдийн засгийн харилцаанд зарчмын өөрчлөлт гарч хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд бий болсон.

Улмаар эдийн засгийн хөгжлийг солонгоруулах тогтворжуулах, “дундаж давхарга”-ыг бий болгох замаар нийгмийн амьдралыг тэнцвэржүүлж бага зардлаар хүмүүсийн нийтлэг хэрэгцээг шуурхай хангаж баялаг бүтээх экспортыг нэмэгдүүлэх ажилгүйдлийг багасгах зэргээр ардчилсан нийгмийг бэхжүүлэх, Улс төрийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, нийгэм эдийн засгийн шинэчлэлийн үндэс болж байдаг.



Өнөөгийн байдал

2019 ОНЫ I УЛИРЛЫН БАЙДЛААР БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ 174.936 АЖ АХУЙ НЭГЖ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА БӨГӨӨД ҮҮНЭЭС 87.725 **ААН** СҮҮЛИЙН 1 ЖИЛИЙН БАЙДЛААР ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА. ҮҮНЭЭС 78 ХУВЬ БУЮУ 56.189 **ААН** ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМААРЧ БАЙНА. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭС ХАРАХАД ЖИЖИГ, ДУНД ҮЙЛВЭРИЙН САЛБАРТ 800.000 ОРЧИМ ХҮН АЖИЛЛАЖ БАЙГАА НЬ НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ 57 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА.


Аж ахуйн нэгж, байгууллага, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар

Бүгд 174 936



87 725

Үйл ажиллагаа явуулж байгаа





ЖДҮ-Д ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Жижиг, дунд үйлдвэрийг төрөөс бодлогоор дэмжих зорилгоор 1993 онд “Худалдаа аж үйлдвэрийн яам” /хуучин нэрээр/, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санг байгуулж, уг сангийн үйл ажиллагааг эхлэх жижиг, дунд үйлдвэрийн анхны хэлтсийг зохион байгуулснаас хойшхи 26-н жилд 5-н яамны дэргэд болон Засгийн газрын агентлаг болж иржээ.

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

Үйлдвэр
Худалдааны
Яам, Жижиг,
дунд үйлдвэрийн
хэлтэс

Жижиг, дунд
үйлдвэрийн
тухай хууль

Хүнс, хөдөө аж
ахуй, хөнгөн
үйлдвэрийн
яам, Жижиг,
дунд
үйлдвэрийг
дэмжих сан

"Үндэсний
үйлдвэрлэгч-
дийг дэмжих,
ажлын байр
нэмэгдүүлэх
зарим арга
хэмжээний
тухай"
УИХ-ын 30
дугаар тогтоол

"Хууль
хэрэгжүүлэх
арга хэмжээний
тухай" 15
дугаар тогтоол,
"Шинэ бүтээн
байгуулалт,
хөтөлбөр"-
ийн хүрээнд
ажлын байр
нэмэгдүүлэх
арга хэмжээний
тухай" ЗГ-ын
2012 оны 138,
208 дугаар
тогтоол

Жижиг дунд
үйлдвэрийг
хөгжүүлэх,
ажлын байр
нэмэгдүүлэх,
ажлын байр
нэмэгдүүлэх
арга хэмжээний
тухай" ЗГ-ын
176-р тогтоол

Үйлдвэржил-
тийг дэмжих
зорилтын
хүрээнд
Экспортыг
нэмэгдүүлэх,
импортыг орлох
бүтээгдэхүүн
үйлдвэрлэлийг
дэмжих, ажлын
байр бий болгох
тухай ЗГ-ын 66
дугаар тогтоол

1993

1999

2003

2005

2007

2009

2010

2011

2013

2014

2015

2014

2016

2020

ЗГ-ын ЖДҮ
дэмжих хөтөлбөр
(1999-2003)

ЗГ-ын ЖДҮ
дэмжих хөтөлбөр
(2005-2010)

ЗГ-ын ЖДҮ
дэмжих
хөтөлбөр
(2014-2016)

ЗГ-ын ЖДҮ
дэмжих
хөтөлбөр
(2016-2020)



Гэвч Монгол улсад судалгаанд суурилсан, өөрийн орны онцлогийг тусгасан нэгдсэн бодлого дутмаг, түүнийг хэрэгжүүлэх механизм бүрдээгүй юм.

Мэргэжлийн холбоодын эрх зүйн байдал тодорхойгүй, төртэй харилцах эрх зүйн зохицуулалт дутмаг, нийгэм, улс төр, макро эдийн засгийн орчин тогтворгүй зэргээс болж, ЖДҮ салбар өнөөдрийг хүртэл хөгжихгүй байна.

гардаг вэ?

Асуулт:

эрхлээд ямар үндсэн хүндрэл гардаг вэ?

Төрийн захиалгат ажил
авахад хэцүү

Эдийн засгийн
тогтворгүй байдал

Татварын систем
хангалтгүй

Төрийн үйлчилгээ
хангалтгүй
Мэргэжилтэй ажилчид
хүрэлцээгүй

Шаардлагатай
мэдээлэл олж авахад...

Зээл авахад хэцүү

Эргэлтийн хөрөнгө

хангалтгүй
Борлуулах зах зээл

ховор

Орон нутгийн зах

зээлийн хөгжил мүү

Иргэдийн худалдан
авах чадвар мүүдсан

Түрээсийн төлбөр
өндөр


Ажлын байрны хангалт
мүү

Тээврийн зардал өндөр

Түүхий эдийн үнэ
өндөр


Орон нутаг

Нийслэл






Асуулт: Таны бодлоор төрийн байгууллагаас ямар төрлийн зөвшөөрлийн баримт бичиг авахад хамгийн их хүндрэл гардаг вэ?





Асуулт: Жижиг, дунд үйлдвэрийн зээл авахад үүсдэг үндсэн хүндрэлийг нэрлэнэ үү





Дээрх хариултуудаас үзэхэд жижиг дунд үйлдвэрлэгчдийн өмнө тулгарч байгаа дараах гол хүндрэл бэрхшээлүүдийг дурдсан байна. Үүнд: төрийн захиалгат ажил авах буюу тендерт оролцох, техник технологийг шинэчлэх, судалгаа шинжилгээний ажил явуулах, мэргэжилтэй ажилтан дутмаг, бүтээгдэхүүний борлуулалт, эдийн засгийн тогтворгүй байдлаас үүссэн хямрал гэх мэт. Түүнчлэн орон нутгийн ихэнх бизнес эрхлэгчид тээврийн зардал өндөр, зах зээл хангалтгүй, шаардлагатай мэдээлэл олж авахад хүндрэлтэй гэж үзсэн байна. Ийм учраас эдгээр асуудлуудыг даван туулахад Мэргэжлийн холбоод чухал үүрэг гүйцэтгэнэ.



ХОРШООД МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДОД ОРОЛЦОХ ҮҮРЭГ

Гишүүдийнхээ хөдөлмөр, оролцоог үнэлж, хамтран хоршин ажиллах боломжийг бий болгох, гишүүдийн илүүдэл хөрөнгийн эх үүсвэрийг бүх гишүүдийн хурлаас тогтоосон хэмжээнд төвлөрүүлэн ашиглаж, үр ашигтай захиран зарцуулах замаар хуримтлал бий болгох, тогтоосон журмын дагуу зээл олгох;

Гишүүдийн эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, экспорт,импортыг нэмэгдүүлэх, түүхий эд, материалаар хангах, хагас боловсруулалт хийх,

Бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний зардал,өртөгийг бууруулах, эрсдлийг саармагжуулах замаар өгөөжийг нэмэгдүүлэх,

Гишүүдэд хуваарилах орлого, ашгийн хэмжээг нэмэгдүүлэх;



Үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх техник, технологийг нэвтрүүлэх, хоршооны санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр эдийн засгийн гадаад харилцаанд оролцох;

Гишүүдийг газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй болоход дэмжих,

Хоршооны эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгийг тэдгээр ашиглуулах /давхар түрээслүүлэх, аж ахуйн зориулалтаар ашиглуулах/



Бөөний болон жижиглэнгийн худалдааны төв, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн боловсруулалтын болон хагас боловсруулалтын жижиг дунд үйлдвэрийг бодлогоор бий болгох,

Түүхий эд боловсруулсан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох, тэдгээрээр дамжуулан хоршооны үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэх, бизнесийн болон удирдлагын арга барил, туршлагыг гишүүдэд зааж сургах;



Гишүүнчлэлийн нээлттэй зарчмыг удирдлага болгож, орлого багатай, амьдралын түвшин доогуур иргэдэд хоршооны үйл ажиллагаагаар дамжуулан гишүүнээр элсч, нийгэм эдийн засгийн байдлаа дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх;

Засгийн газар болон бусад хоршоо, байгууллагуудтай хамтран ажиллах,

Эдийн засгийн өсөлтөд нөлөөлж, ядуурлыг бууруулах зорилгоор өөртөө туслах, өөрөө ажлын байр бий болгох явдлыг дэмжих;



ЖДҮ ЭРХЛЭГЧДИЙН ҮҮРЭГ

Эвлэлдэн нэгдэж, салбарын мэргэжлийн холбоодод гишүүнээр элсэж, хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх;

Зохих стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх;

Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;



Бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;

Ажиллагчдын мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, удирдлага, менежментийн арга барилыг сайжруулах;



Шинжлэх ухаан, техникийн ололт, дэвшилт техник технологи нэвтрүүлэх чиглэлээр төрийн холбогдох байгууллагатай хамтран ажиллах санал, санаачлагыг байнга гаргаж, хэрэгжүүлэх арга замыг мэргэжлийн холбоотой хамтран эрэлхийлдэг байх;

Инноваци, дэвшилт санааг нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллага, дэмжигч мэргэжлийн холбооны оролцоотойгоор бүх шатны ажиллагсдаа сургах ажлыг эрчимжүүлэх зэрэг болно.



ОЛОН УЛСЫН ЖИШИГ

БНХАУ:

Хятадын ЖДҮ-ийн Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг нь Хятад улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, нийгмийн бүлгүүдээс бүрддэг үндэсний хэмжээний жижиг, дунд үйлдвэрийн анхны байгууллага юм.

Хятад улсын эдийн засгийн үзүүлэлтэд жижиг, дунд үйлдвэрийн сектор ДНБ-ий 53 хувийг, экспортын бүтээгдэхүүний 60 хувийг, нийт бүтээгдэхүүний 80 хүртэл хувийг тус тус эзэлж байгаа нь Хятадын эдийн засгийн өсөлтийг хангах, зах зээлийг сэргээхэд чухал хүчин зүйл болдог жижиг, дунд үйлдвэрийн хөгжил нь улс гүйцэтгэж ирсэн.



АНУ:

Жижиг бизнесийн захиргаа нь зохион байгуулалт, бүтцийн хувьд үр ашигтай хувилбар болох нь тодорхой байна. Уг газар нь жижиг, дунд үйлдвэрийг АНУ-ын тогтвортойхөгжлийн баталгаа болгоод зогсохгүй жижиг, дунд үйлдвэрийн хүчин чадлыг тодорхойлж, европын холбооны улсууд, англи, япон, болон бусад орнууд жижиг, дунд үйлдвэрийн дэмжлэгийн тогтолцоондоо нутагшуулан ашиглаж байна. Төрөөс жижиг, дунд үйлдвэрийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү байгууллага нь Засгийн газрын ямар нэг байгууллагад бус зөвхөн ерөнхийлөгчид шууд харьяалагдан ажиллаж ирсэн байна. Тус байгууллагыг ерөнхийлөгчийн санал болгосноор Сенатаар батлагдсан зөвлөл удирддаг байна.



МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫГ ЯМАР ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛАХ ВЭ?

- Экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;
- Үйлдвэрлэл-технологийн парк дагасан;
- Эрчимжсэн мал аж ахуй буюу фермерийн аж ахуй;
- Том үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний эд ангийг үйлдвэрлэгч, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгч, хангагч аж ахуйн нэгжүүд; (кластер)
- Өрхийн үйлдвэрлэлд суурилсан бичил үйлдвэрлэл эрхлэх;
- Нийтийн ахуйн (үсчин, зурагчин, оёдол, хими цэвэрлэгээ гэх мэт) үйлчилгээ эрхлэх;
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэл эрхлэх;
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх;
- Барилга, барилгын засвар, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх;
- Машин, механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний;
- Био болон нано технологи, электроник, мэдээллийн технологи;



Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд бизнесээ эхлүүлэх, санхүү, татвар болон үйл ажиллагааны стандарттай холбоотой хууль эрхзүйн таатай орчин бий болгох нь аж ахуйн нэгжийн тогтвортой өсөлтийг дэмжиж, өрсөлдөх чадвараа бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг. Кластерийн хөгжлөөр дэлхийн олон оронд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, улмаар тухайн улсын экспортын чадавхийг нэмэгдүүлж хөгжлийг хурдасгах гол арга хэрэгсэл гэж үзэж байна. Монгол улсад кластерийг хөгжүүлэх нь олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох, жижиг дунд үйлдвэрийг эрчимжүүлэх өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чухал нөхцөлийн хамгийн гол зүйл нь Мэргэжлийн холбоодод ЖДҮ эрхлэгч, хоршоологчид эвлэлдэн нэгдэж, түүгээрээ эрх ашгаа хамгаалуулах явдал юм.

Мөн жижиг, дунд үйлдвэрийн менежер, ажилтнуудын чадамж, ур чадварыг хөгжүүлэх нь тухайн аж ахуй нэгжийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байхад чухал нөлөө үзүүлдэг болоход мэргэжлийн холбоод чухал үүрэг гүйцэтгэнэ.





Анхаарлаа хандуулсан
та бүхэнд баярлалаа.